



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/137

Булган сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Доройтсон бэлчээрийн газрыг нөхөн сэргээх, ойн зурвасын усалгааны зориулалтаар шинээр худаг гаргах (10 ш)” ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга:	Б.Баярцэнгэл (Худалдан авах ажиллагааны газрын дарга)
Гишүүд:	Э.Уянга (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн) А.Ганхуяг (Хүнс, хөдөө аж ахуйн газрын мэргэжилтэн)
Иргэний төлөөлөл:	Б.Туяа (Булган сумын иргэн)
Нарийн бичгийн дарга:	Б.Эрдэнэтуяа (Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Баярцэнгэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.БҮРЭВ-ОЧИР



Сугар Ажил 2025 өдөр бүр Дос/2025/Захирамж

6325010202